

Хан-Уул дүүрэг "Хүн ам зүй, шилжилт хөдөлгөөн ба хэрэгцээ шаардлага" Түргэвчилсэн судалгаа

2022 оны 7-р сар



© З.Эрдэнэ

Агуулга

Удиртгал ба аргачлал	1
Мэдээллийн дүн шинжилгээ.....	2
1.1 Хүн амын суурь тоон үзүүлэлт ба хүн ам зүйн тойм.....	2
1.2 Ирсэн иргэд.....	3
1.3 Явсан иргэд.....	3
1.4 Хөдөлмөр эрхлэлт.....	4
1.5 Санхүүгийн нөхцөл байдал.....	5
1.6 Тулгамдаж буй асуудал, аюулгүй байдал.....	6
1.7 Үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц.....	10
1.8 Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж.....	14
1.9 Тээвэр, замын хөдөлгөөний нөхцөл байдал.....	15
1.10 Хүүхэд болон боловсрол.....	16

Удиртгал ба аргачлал

Удиртгал

Дүүргийн түвшний энэхүү тайланд 2022 оны 3-р сард Улаанбаатар хотын хэмжээнд хүн ам, шилжилт хөдөлгөөн, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох шуурхай үнэлгээнд тусгагдсан үндсэн болоод сэдэвчилсэн бүх чиглэлийн тойм мэдээллийг багтаасан болно.

Энэхүү тайлан нь Хан-Уул дүүргийн хэмжээнд найман үндсэн сэдвийг хамарсан судалгааг багтаасан; тухайлбал, хүн амын суурь тоон үзүүлэлт, хүн ам зүй, ирсэн болон явсан иргэд (шилжилт хөдөлгөөн), хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд ба аюулгүй байдал, үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, хүүхэд болон боловсрол. Мэдээллийг дүүргийн нутаг дэвсгэр, хүний нөөц, засаг захиргааны нэгжийн харилцааны талаарх мэдлэг өндөртэй мэдээлэл нэгтгэгчид болох хэсгийн ахлагч нартай ярилцлага хийх замаар олж авсан болно.

Энэхүү судалгааны үндэслэл, хэрэгцээ шаардлагын талаар дэлгэрэнгүй мэдээллийг Улаанбаатар хотын дэлгэрэнгүй тайлангаас авч үзнэ үү.

Аргачлал

Энэхүү тайланд ОУШХБ-ын Шилжих хөдөлгөөнийг тандах матриц (ДТМ)-ийн нэгжээс боловсруулсан хөдөлгөөнийг тандах (МТ) аргачлалыг ашигласан болно.

Судалгаанд хөдөлгөөнийг тандах (МТ) аргачлалыг ашигласан Улаанбаатар хотын хамгийн жижиг засаг захиргааны нэгж болох хэсгийн түвшинд хэсгийн ахлагч нараас мэдээллийг цуглуулав. Хэсгийн ахлагч нар иргэдтэй ярилцах, ажиглалт хийх болон өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан, харилцаа холбооны хэрэгслүүдийг ашиглан тоон мэдээллийг нягтлах, баталгаажуулах ажлыг хийхээр төлөвлөсөн юм. Хэсгийн ахлагч нарыг хүн амын суурь тоон үзүүлэлт, шилжин ирэгсэд ба явагсад, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, аюулгүй байдал, үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц, ногоон байгууламж, хүүхэд ба боловсрол гэсэн найман үндсэн сэдвийг багтаасан судалгааны асуулгыг бөглөхийг хүссэн юм.

Хэсгийн ахлагч нар Кобо программ хамгамжаар дамжуулан тоон мэдээллийг гар утас эсвэл таблет, компьютер ашиглан бөглөж илгээсэн. Хэсгийн ахлагч нарыг ДТМ судалгааны аргачлал, судалгааны асуулга, түүнийг нөхөхтэй холбоотой танхимын сургалтад бүрэн хамруулсан. Түүнчлэн ДТМ-ийн баг мэдээлэл цуглуулах явцад үүссэн аливаа асуулт, асуудалд цаг тухайд нь хариу өгч бэлэн байдалд ажилласан юм.


Өгөгдөл оруулах үйл явц албан ёсоор хаагдмагц ДТМ-ийн баг бүрэлдэхүүн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажлыг эхлүүлсэн бөгөөд өгөгдөл оруулахад гарч болзошгүй алдаа, тоон мэдээллийн зөрүү, давхардал зэргийг илрүүлэхийн тулд өгөгдлийн хяналтын шатанд чанарын баталгаажуулалтын шалгалтыг хийсэн. Өгөгдөлтэй холбоотой аливаа асуудал илэрсэн тохиолдолд ДТМ-ийн баг тодруулга авахаар хэсгийн ахлагч нартай утсаар холбогдож тоон мэдээллийг тодруулж, баталгаажуулсан байна. Бүх хяналт, шалгалтыг хийж дууссаны дараа мэдээлэлд дүн шинжилгээ хийх үе шатанд шилжсэн. Бүх судалгааны үр дүнг хэсгийн түвшинд дүн шинжилгээ хийж, дараа нь дүүргийн болон хотын хэмжээнд нэгтгэн дүгнэв. Иймээс дүүрэг, хотын түвшинд энэхүү тайланд тусгагдсан аливаа үр дүнг хэсгийн түвшинд ч авах боломжтой гэдгийг дурдах нь зүйтэй юм.

Хязгаарлагдмал байдал, судалгааны аргачлалын талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг Улаанбаатар хотын хэмжээний нэгдсэн тайлангаас үзнэ үү.




1. МЭДЭЭЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ - ХАН УУЛ ДҮҮРЭГ

1.1 Хүн амын суурь тоон үзүүлэлт ба хүн ам зүйн тойм



Хүн ам зүй (эзлэх хувь)




Үнэлгээ хийх үед (2022 оны 3-р сар) Хан-Уул дүүрэгт 216,980 иргэн, 58,841 өрх амьдарч байв. Үүнээс 47 хувь нь эрэгтэй, 53 хувь нь эмэгтэй байна. Нийт хүн амын 36 хувь нь насанд хүрээгүй гэж бүртгэгдсэн байна. 12 хувь нь 0-5 насныхан, 24 хувь нь 6-17 насныхан байгаа нь Улаанбаатар хотын хэмжээнд нэг дүүрэгт бүртгэгдсэн хүүхдүүдийн хамгийн өндөр нэгдсэн хувь юм. Хүн амын 58 хувийг 18-65 насны насанд хүрэгчид, 6 хувийг өндөр настан (65-аас дээш насныхан) эзэлж байна.

Нийтдээ 2,567 хүн архаг хууч эсвэл хүнд өвчтэй (хүн амын 1,2%), 2,879 эмэгтэй (эмэгтэйчүүдийн 2,5%) жирэмсэн гэж бүртгэгджээ.

Хан-Уул дүүрэг нь 21 хороо, 201 хэсэгтэй. Дүүргийн хүн амын арван хүн тутмын нэг нь амьдардаг 4-р хороо хамгийн олон хүн амтай, дараа нь 16-р хороо (8%), 15-р хороо (7%) ордог.


Хүн ам зүйн тойм хүйсээр, хороогоор (эзлэх хувь)



1.2 Ирсэн иргэд²

Хан-Уул дүүрэгт 2021 онд нийт 7,216 өрх буюу 20,633 иргэн ирсэн. 2021 онд Улаанбаатар хотод нийт ирсэн иргэдийн 17.2 хувь нь Хан-Уулд бүртгэгдсэнээс хамгийн өндөр хувь нь 4-р хороонд (15%) байна. Энэ дүүрэгт ирсэн гол шалтгаан нь гэр бүл (42%), дараа нь боловсрол (19%), эдийн засгийн шалтгаан (9%) байв.


Ирсэн иргэд хамгийн их бүртгэгдсэн хороо (ирсэн иргэдийн эзлэх хувь)




1.3 Явсан иргэд

2021 онд Хан-Уул дүүргээс нийт 2,578 өрх буюу 7,385 иргэн явсан. 2021 онд Улаанбаатар хотын хэмжээнд нийт явагсдын 8.5 хувь нь Хан-Уул дүүргээс явсан байна. Хамгийн өндөр хувь нь 16-р хороо (18%), дараа нь 9-р хороо (13%), 10-р хороо (10%-ноос гарчээ. Ерөнхийдөө энэ дүүргээс гарах хамгийн чухал шалтгаан нь гэр бүлийн шалтгаан (30%) байв.

Явсан иргэд хамгийн их бүртгэгдсэн хороо (ирсэн иргэдийн эзлэх хувь)



Ирсэн, явсан үндсэн шалтгаанууд (эзлэх хувь)




² Ирсэн иргэд гэдэг нь Улаанбаатар хотын дотор эсвэл хотын гаднаас ирсэн эсэхээс үл хамааран Улаанбаатар хотын аль нэг байршилд оршин суухаар ирсэн иргэн, айл өрхийг хэлнэ. Явсан иргэд гэдэг нь Улаанбаатар хотын аль нэг байршлаас явсан эсэхийг үл хамааран явсан иргэн, айл өрхийг хэлнэ.


1.4 Хөдөлмөр эрхлэлтийн байдал

Хотын чиг хандлагын дагуу Хан-Уул дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн хамгийн том салбар нь бөөний болон жижиглэнгийн худалдаа (27%), барилгын салбар (23%) байна. Харин хотын чиг хандлагаас ялгаатай нь Хан-Уул дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн гурав дахь чухал салбар нь уул уурхай, олборлолт, бусад үйлдвэрлэлийн үйл ажиллагаа (7%) юм. Бөөний болон жижиглэнгийн худалдаа 6-р хороо (хэсгүүдийн 100%), дараа нь 2-р хороо (хэсгүүдийн 55%), 16-р хороо (хэсгүүдийн 53%)-нд хамгийн их түгээмэл байна. Барилгын ажил 9-р хороо (хэсгүүдийн 92%), 11-р хороо (хэсгүүдийн 63%), 8-р хороо (хэсгүүдийн 53%)-нд хамгийн түгээмэл байдгийг мэдээлжээ. Энэ нь мөн хамгийн олон хүн амтай буюу 21,107 хүнтэй (дүүргийн хүн амын 10%) 4-р хорооны хөдөлмөр эрхлэлтийн тэргүүлэх салбар юм. Бөөний болон жижиглэнгийн худалдаа хамгийн ихээр эрхэлдэг хэсгүүдэд нийт 56,478 иргэн (дүүргийн хүн амын 26%) амьдардаг бол барилгын салбарт хамгийн их ажилладаг хэсгүүдэд 47,037 иргэн (дүүргийн хүн амын 22%) амьдарч байна.


Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар (хэсгийн эзлэх хувь)




Хөдөлмөр эрхлээгүй хүн ам (18-64 насны иргэдийн эзлэх хувь)



Хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь, хороогоор (18-64 насны иргэдийн эзлэх хувь)



Хөдөлмөр эрхлэлтийн төрөл (хэсгийн эзлэх хувь)



Хан-Уул дүүргийн хэмжээнд 18-64 насны 32,602 хүн хөдөлмөр эрхлээгүй байгаа нь насанд хүрсэн хүн амын 26 хувийг эзэлж байна. Энэ дүүрэг хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувиар Улаанбаатар хотын хэмжээнд доороосоо хоёрдугаарт ордог бөгөөд улсын дунджаас дөрвөн хувийн пунктээр доогуур (30%) байна. Энэ нь ялангуяа Хан-Уул дүүрэг нь Улаанбаатар хотын хүн амын 14 хувь оршин суудаг, хүн амын тоогоор дөрөвдүгээрт ордог дүүрэг гэдгийг тооцвол нэлээд ач холбогдолтой юм. Хан-Уул дүүргийн насанд хүрэгчдийн хөдөлмөр эрхлэлт харьцангуй сайн байгаа нь тус дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн салбарууд олон төрлийнх байгаатай холбоотой байж болох бөгөөд энэ нь хөдөлмөр эрхлэх боломж өндөр байгааг илтгэж байна. Хөдөлмөрийн насны хүн амын талаас илүү хувь нь (53%) ажилгүй байгаа 9-р хороо, дараа нь 1-р хороо (50%), 17-р хороо (42%)-нд ажилгүйдлийн түвшин хамгийн өндөр байна. Тэдгээр гурван хороонд хөдөлмөрийн насны нийт 19,122 иргэн байгаагаас 9,051 иргэн хөдөлмөр эрхлээгүй гэсэн мэдээлэл байна. Харин эсрэгээрээ хөдөлмөрийн насны хүн амын 92% (10,811 хүн тутмын 9,977) хөдөлмөр эрхэлдэг 16-р хороо, дараа нь 5-р хороо (90%), 19-р хороо (86%)-нд хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь хамгийн бага байна. Тэдгээр хороонд хөдөлмөрийн насны нийт 21,285 иргэн байгаагаас 19,083 нь хөдөлмөр эрхэлдэг гэсэн мэдээлэл байна.

Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэр дэх хэсгүүдийн 61 хувьд хувийн хэвшил тэргүүлдэг бол 15 хувьд төрийн алба, 15 хувьд хувиараа хөдөлмөр эрхлэлт, 4 хувьд нь мал аж ахуйн ажил зонхилж байна. Хувийн хэвшил 6-р хороо (хэсгүүдийн 100%), дараа нь 9-р хороо (92%), 5-р хороо (88%)-нд хамгийн их байна. Төрийн алба 2-р хороо (хэсгүүдийн 82%), дараа нь 3-р хороо (50%), 21-р хороо (43%)-нд хамгийн түгээмэл байна. Зөвхөн 14-р хороо (хэсгүүдийн 57%), 13-р хороо (38%), 12-р хороо (13%), 17-р хороо (10%) гэсэн дөрвөн хороонд иргэд мал маллан амьдарч байна.

1.5 Санхүүгийн нөхцөл байдал

Энэ хэсэгт орлогын болон хүнсэнд зарцуулах зардлын бууралттай холбоотой асуудлаар санхүүгийн байдлыг судалсан болно.

Нийтдээ, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байгаа хэсгүүдийн 25 хувьд нь мэдээлэл нэгтгэгчид мэдээлэл цуглуулахаас өмнөх дөрвөн долоо хоногийн хугацаанд айл өрхүүд хангалттай идэх хоолгүй байна гэсэн санаа зовнилоо илэрхийлсэн гэж мэдээлсэн бөгөөд энэ нь нийт 43,858 хүнд нөлөөлжээ. Энэ хувь нь хотын дундаж болох 29 хувиас дөрвөн пунктээр доогуур үзүүлэлт юм. 5-р хороо хамгийн их өртөж байгаа бөгөөд бүх хэсгүүдийн мэдээлэгчид хоол хүнс хүрэлцэхгүй байна гэсэн санаа зовнил байгааг мэдээлжээ.

Хэсгүүдийн 26 хувьд нь мэдээлэл нэгтгэгчид мэдээлэл цуглуулахаас өмнөх дөрвөн долоо хоногийн хугацаанд айл өрхүүд хүнсний хэрэглээгээ багасгасан тухай сонссон гэж мэдээлсэн нь нийт 45,676 хүнд нөлөөлсөн байна. Энэ үзүүлэлт мөн хотын дундаж болох 34 хувиас 8 пунктээр доогуур байна. 8-р хороо үүнд хамгийн их өртөж байгаа бөгөөд хэсгүүдийн 93 хувьд нь мэдээлэгчид айл өрхүүд хүнсний хэрэглээгээ бууруулж байна гэж мэдээлжээ.

Хүнсний аюулгүй байдал (хэсгийн эзлэх хувь)


Хүнсний хэрэглээ хангалтгүй байгаад санаа зовних




Хүнсний хэрэглээгээ багасгасан



Сүүлийн 4 долоо хоногт орлого нь буурсан иргэд (хэсгийн эзлэх хувь)



Сүүлийн 4 долоо хоногт бүх орлогоо алдсан иргэд (хэсгийн эзлэх хувь %)




Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байгаа хэсгүүдийн 89 хувьд нь мэдээлэл цуглуулахаас өмнөх дөрвөн долоо хоногийн хугацаанд нийт оршин суугчдын талаас бага хувь нь бараг хэн ч орлого буураагүй гэж мэдээлсэн байна. Гэхдээ хэсгүүдийн 11 хувьд нь оршин суугчдын тал буюу талаас илүү хувь нь орлогоо алдаж, энэ нь 22,005 хүнд нөлөөлсөн байна. Хэсгүүдийн 94 хувьд нь мэдээлэл цуглуулахаас өмнөх дөрвөн долоо хоногийн хугацаанд оршин суугчдын талаас бага буюу бараг хэн ч бүх орлогоо алдаагүй гэж мэдээлсэн байна. Гэхдээ хэсгүүдийн 16 хувьд нь оршин суугчдын тал буюу талаас илүү хувь нь бүх орлогоо алдсан гэж мэдээлсэн нь 11,408 хүнд нөлөөлсөн байна.

1.6 Тулгамдаж буй асуудал болон аюулгүй байдал

Хан-Уул дүүргийн хэмжээнд хамгийн тулгамдсан асуудал нь санхүү, эдийн засгийн тогтворгүй байдал төдийгүй үндсэн үйлчилгээний хомсдолтой холбоотой. Хамгийн их мэдээлж байгаа тулгамдсан асуудал бол орлого хангалтгүй (хэсгүүдийн 46% нь мэдээлсэн), дараа нь тухайн хэсгийн хөдөлмөр эрхлээгүй хүн амын тоо их (18%), үндсэн үйлчилгээний хүртээмжгүй байдал (14%) байна. Орлого хангалтгүй гэсэн асуудал 3-р хороонд хамгийн их тулгардаг бөгөөд энэ талаар хорооны бүх хэсгүүд мэдээлжээ.

Тулгамдаж буй асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




Хан-Уул дүүргийн хэмжээнд иргэдийн амьжиргаа, ажлын байр, орлого бий болгох боломж (21%), эрүүл мэндийн үйлчилгээ (19%), авто машины зогсоол (16%) зэрэг үйлчилгээг авахад хамгийн хүндрэлтэй байсан байна. 5-р хорооны хэсгүүдийн 75 хувьд нь амьжиргааны боломж нэн тэргүүний тулгамдсан асуудал байсан бол 9-р хорооны хэсгүүдийн 58 хувьд нь эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн асуудал хамгийн их анхаарал татдаг байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгарч буй үндсэн бэрхшээл нь тусгай зориулалтын эмнэлгийн тусламж үйлчилгээ (42%), дараа нь гудамж, цэцэрлэгт хүрээлэн, барилга байгууламжид аюулгүй нэвтрэх дэд бүтэц дутмаг (35%) байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгамдаж буй асуудал (хэсгийн эзлэх хувь)



Хүндрэлтэй байдаг үйлчилгээ (хэсгийн эзлэх хувь)




Аюулгүй байдал, Хороогоор Оноо: 1= маш муу, 2= муу, 3= дундаж, 4= сайн, 5= маш сайн




Аюулгүй байдлыг хөндсөн асуудал гарсан эсэх (хэсгийн эзлэх хувь %)

Аюулгүй байдлыг хөндсөн асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




1.7 Дэд бүтэц, үйлчилгээ, УС

Усны хэрэглээгүй байгаа хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Устай холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ

Цахилгааны хэрэглээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Цахилгааны хэрэглээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




ХООЛ, ХҮНС

Хүнсний бүтээгдэхүүн хүрэлцээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Хүнсний бүтээгдэхүүн хүрэлцээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




ОРОН БАЙР

Орон байрны хүрэлцээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Орон байртай холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




1.7 Дэд бүтэц, үйлчилгээ

ХҮНСНИЙ БУС ЗҮЙЛС

Хүнсний бус бүтээгдэхүүн хүрэлцээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Хүнсний бус бүтээгдэхүүнтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




ИНТЕРНЭТ

Интернэтэд холбогдоогүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Интернэтийн хэрэглээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




ЭРҮҮЛ МЭНД

Эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




УХААЛАГ УТАС

Ухаалаг утас ашигладаггүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)



Ухаалаг утасны хэрэглээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




1.8 Ногоон байгууламж

Мэдээлэл нэгтгэгчдээс өөрийн хэсгийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанарт нэгээс тав хүртэл, нэг нь маш муу, тав нь маш сайн гэсэн үнэлгээ өгөхийг хүссэн. Дүүргийн хэмжээнд хувийн хэвшлийн ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн чанар дунджаас бага байсан бол хувийн хэвшлийн ногоон байгууламжийн чанар маш муу байна. Өрхийн ногоон байгууламжийн чанар 18-р хороонд хамгийн өндөр (4.2), 20 дугаар хороонд (1.9) хамгийн бага байна. Мөн хувийн хэвшлийн ногоон байгууламжийн чанар 18-р хороонд хамгийн өндөр (4.2), 16-р хороонд (1.7) хамгийн бага байна. Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн чанар дахин 18-р хороонд хамгийн өндөр (3.8), 14, 7-р хороодод хамгийн бага (хоёулаа 1.9) байна.


Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар (хэсгийн эзлэх хувь %)

Оноо: 1= маш муу, 2= муу, 3= дундаж, 4= сайн, 5= маш


Өрхийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар



Хувийн хэвшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар




Нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар




Хороо #	Өрхийн ногоон байгууламж	Хувийн хэвшлийн ногоон байгууламж	Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж
Хороо #1	2.8	2.7	3.0
Хороо #2	2.6	2.2	3.0
Хороо #3	2.4	2.4	2.3
Хороо #4	3.0	2.9	3.1
Хороо #5	2.1	2.3	1.9
Хороо #6	2.1	2.0	2.1
Хороо #7	2.6	2.3	1.9
Хороо #8	2.5	2.0	2.0
Хороо #9	3.4	2.3	2.1
Хороо #10	2.0	2.0	1.9
Хороо #11	2.8	2.8	2.4
Хороо #12	3.0	2.9	2.8
Хороо #13	2.8	3.0	3.0
Хороо #14	2.6	2.1	1.9
Хороо #15	2.8	2.6	2.7
Хороо #16	2.1	1.7	1.9
Хороо #17	2.8	2.7	3.4
Хороо #18	4.2	4.2	3.8
Хороо #19	2.9	2.6	2.9
Хороо #20	1.9	2.0	1.9
Хороо #21	2.1	2.3	2.3

1.9 Зам тээвэр ба хөдөлгөөн

Хувийн тээврийн хэрэгсэлгүй өрх (хэсгийн эзлэх хувь)



Тээврийн үндсэн аргууд (хэсгийн эзлэх хувь)



Замын хөдөлгөөнтэй холбоотой үндсэн асуудлууд (хэсгийн эзлэх хувь)



Хан-Уул дүүрэгт тээврийн хэрэгслийн зонхилох арга нь авто машин (хэсгүүдийн 43%) гэж мэдээлсэн. Замын хөдөлгөөнтэй холбоотой гарч болзошгүй бүх асуудал бүртгэгдсэн байна. Дүүргийн хэмжээнд замын хөдөлгөөний хамгийн хүндрэлтэй асуудал нь ачаалал хэт ихтэй (22%), дараа нь зогсоолын хүрэлцээ муу (16%) байна. 2-р хороонд замын хөдөлгөөний ачаалал их байгаа нь хамгийн гол асуудал гэж хэсгийн хороодын 82 хувь нь мэдээлжээ.



© У.Одбаяр

1.10 Хүүхэд ба боловсрол

Хан-Уул дүүргийн хэмжээнд 0-5 насны 6,418 хүүхэд цэцэрлэгт хамрагдаагүй (тухайн насны хүн амын 25%), 6-17 насны 1,662 хүүхэд (тухайн насны хүн амын 3%) сургуульд хамрагдаагүй байна. Дүүргийн хэмжээнд 0-5 насны хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдаагүй түвшин хотын дунджаас таван пунктээр бага байна. 0-5 насны хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдаагүй түвшин 3-р хороонд (65%) хамгийн өндөр, харин 6-17 насны хүүхдүүдийн хувьд хамгийн өндөр нь 15-р хороонд (31%) сургуульд хамраглаагүй байна.

Хүүхдүүдийн ерөнхий нөхцөл байдлыг илүү өргөн хүрээнд судлахын тулд мэдээлэл нэгтгэгчээс хүүхдүүдэд тулгардаг үндсэн асуудал өөрсдийн хэсгийн нутаг дэвсгэр дээр хэр байгаа талаар асуусан. Хан-Уул дүүргийн хэсгүүдийн 32 хувь нь сургуулиуд хэт хол байна гэж хариулсан бол 31 хувь нь асуудалгүй гэж хариулжээ. Хэсгүүдийн ихэнх хувь нь боловсролтой холбоотой асуудал байгаа гэж мэдээлсэн цорын ганц дүүрэг нь Хан-Уул байсан. Дүүргийн хэмжээнд хүүхдүүдтэй холбоотой хамгийн их бүртгэгдсэн хоёр тулгамдсан асуудал бол хүүхдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх секц, дугуйлан дутмаг (хэсгүүдийн 34%) болон сургууль хэт хол (18%) гэсэн хариулт байв.

Сургуульд хамрагдаагүй хүүхдүүд (хэсгийн эзлэх хувь)


0-5 насны цэцэрлэгт хамрагдаагүй хүүхэд




6-17 насны сургуульд хамрагдаагүй хүүхэд



Боловсролтой холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)



Хүүхдэд тулгамдаж буй үндсэн асуудлууд (хэсгийн эзлэх хувь)



Уг тайлангийн үр дүн, дүгнэлт нь зөвхөн судалгааны багийн байр суурийг илэрхийлэх бөгөөд ОУШХБ, түүний гишүүн улсууд, Швейцарын хөгжлийн агентлаг болон бусад хандивлагчдын байр суурийг илэрхийлэхгүй болно. Тайлангийн туршид ашигласан тэмдэглэгээ болон материалын танилцуулга нь аливаа улс орон, нутаг дэвсгэр, хот, бүс нутгийн эрх зүйн байдлын талаар ОУШХБ-ын зүгээс ямар нэгэн үзэл бодлоо илэрхийлэх, эсхүл түүний эрх баригчид, хил хязгаарыг илэрхийлээгүй болно.

ОУШХБ нь шилжин суурьшигчид, хөдөлгөөнт хүн ам болон нийгэмд тустай, хүмүүнлэг, аюулгүй, цэгцтэй шилжилт хөдөлгөөний зарчмыг баримтлан ажилладаг. ОУШХБ нь засгийн газар хоорондын байгууллага, олон улсын хамтын нийгэмлэгийн түншүүдтэйгээ дараах зорилтын хүрээнд хамтран ажилладаг. Үүнд: Шилжилт хөдөлгөөний үйл явц дахь сорилтыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх; шилжилт хөдөлгөөний асуудлын талаар мэдлэг мэдээллээ дээшлүүлэх; шилжилт хөдөлгөөнөөр дамжуулан нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих; мөн шилжин суурьшигчдын нэр төр, сайн сайхныг дээдлэх зэрэг болно.

Энэхүү тайлан нь Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэйгээр, ОУШХБ-аас хэрэгжүүлж буй “Монгол Улс дахь дотоод шилжилт хөдөлгөөнийг ойлгож, удирдах нь” төслийн хүрээнд хийгдэж буй ажлуудаас гаргаж буй үр дүнгийн нэг хэсэг юм. Энэхүү төслийн зорилго нь Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицыг (ДТМ) ашиглан Монгол Улсын дотоод шилжилт хөдөлгөөн, хөгжлийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх замаар нотолгоонд суурилсан томъёолол, хэрэгжилтийг бэхжүүлэн бататгахад оршино. Судалгааны аргачлал, арга зүй, дүн шинжилгээ, тайланг загварчлах ажлыг ОУШХБ-ын ДТМ хариуцсан ОУ-ын зөвлөх Витторио Бруни, дотоодын зөвлөх Ганбатын Гэрэлтогтох, туслах ажилтан Болор-эрдэний Маналцогзолын хамт боловсруулсан болно. Судалгааны асуулгыг ОУШХБ-ын баг, НЗДТГ-ын оролцоотойгоор боловсруулсан байна. Судалгааны мэдээллийг ОУШХБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн алба болон Глобал ДТМ-ийг дэмжих багийн удирдлагуудын техникийн дэмжлэгтэйгээр Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицын (ДТМ) хэрэглүүрийг ашиглан цуглуулж, дүн шинжилгээ хийсэн болно.